



ДУНДГОВЬ АЙМГИЙН  
ГЭР БҮЛ, ХҮҮХЭД, ЗАЛУУЧУУДЫН  
ХӨГЖЛИЙН ГАЗАР

**ДУНДГОВЬ АЙМГИЙН  
ГЭР БҮЛ, ХҮҮХЭД, ЗАЛУУЧУУДЫН ХӨГЖЛИЙН ГАЗРЫН  
ДАРГЫН ТУШААЛ**

2020 оны 07 сарын 03 өдөр

Дугаар А/45

Мандалговь

**Хурдан морины уралдаанч хүүхдийн аюулгүй  
байдалд хяналт тавьж ажиллах тухай**

Хүүхэд хамгааллын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.6, Хүүхдийн эрхийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1, 14 дүгээр зүйлийн 14.1.1, 14.1.4, 15 дугаар зүйлийн 15.1.4, Үндэсний их баяр наадмын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2, Төсвийн тухай хуулийн 16.5.5, Байгууллагын 2020 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний 3.2.1.5 дахь заалтуудыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Ардын хувьсгалын 99 жил, Дундговь аймаг байгуулагдсаны 79 жил, Сайнцагаан сум байгуулагдсаны 96 жил, Мандалговь хот байгуулагдсаны 55 жилийн ойн баяр наадмын хурдан морины уралдаанч хүүхдийн аюулгүй байдлыг ханган, хяналт тавьж ажиллах ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг 1 дүгээр, төсвийн тооцоог 2 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Үйл ажиллагаанд шаардагдах 1 969 400 (Нэг сая есөн зуун жаран есөн мянга дөрвөн зуу) төгрөгийг Нийгмийн бүлэгт чиглэсэн хөтөлбөрөөс санхүүжүүлэхийг нягтлан бодогч (С.Чинбат)-д зөвшөөрсүгэй.

3. Тушаалын хэрэгжилтийг хангаж, үр дүнтэй зохион байгуулж ажиллахыг ажлын хэсгийн ахлагч (Ш. Эрдэнэсүвд), гишүүдэд үүрэг болгосугай.

4. Үйл ажиллагааны хэрэгжилтэнд хяналт тавьж, үр дүнг 2020 оны 07 дугаар сарын 25-ны өдрийн дотор даргын дэргэдэх зөвлөлд танилцуулахыг ажлын хэсгийн ахлагч (Ш. Эрдэнэсүвд)-д даалгасугай

ДАРГА

Ц.ГАНЗОРИГ



481190087